

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “ЗАВХАНЧУУДЫН ХӨГЖИЛ ДЭВШИЛ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Завхан аймаг нь Монгол Улсын ууган 4 аймгийн нэг юм. Эх орны баруун хэсэгт орших бөгөөд хангай, говь, хээр тал хосолсон 82.4 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, 20.7 мянган өрхийн 70.1 мянган хүн амтай, засаг захиргааны 24 сум, 115 багтайгаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Нийт хүн амын 50.1 хувийг эрэгтэй, 49.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж, хүн амыг насны бүтцээр авч үзвэл 29.0 хувийг 0-14 насны хүүхдүүд, 65 хувийг 15-59 насныхан буюу хөдөлмөр эрхлэх насныхан, 6 хувийг 60-аас дээш насны ахмадууд эзэлж байгаагаас харахад аймгийн хүн амд залуусын эзлэх хувь их байна.

2015 оны байдлаар 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 32.9 мянга болж, нийт хүн амын 47.2 хувийг эзлэж байна.

Хүн амыг суурьшлаар нь авч үзвэл: Аймгийн нийт хүн амын 22.8 хувь нь Улиастай суманд, 12.6 хувь нь Тосонцэнгэл суманд, 8.8 хувь нь Их-Уул суманд, 55.8 хувь нь бусад сумдад оршин сууж байна.

2015 онд аймгийн хэмжээгээр 313.2 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ үйлдвэрлэсний 46,4 хувийг хөдөө аж ахуй, 12.6 хувийг аж үйлдвэр барилгын, 41.0 хувийг худалдаа, үйлчилгээний салбар тус тус эзэлж, нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувийн жин харьцангуй бага байна. 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4763.4 мянган төгрөгт хүрсэн нь улсын дундажтай харьцуулахад 2186.4 мянган төгрөгөөр бага байна.

Аймагт дэд бүтэц сул хөгжсөн, төвөөс алслагдсан зэргээс шалтгаалж хүн амын шилжилт хөдөлгөөн их, хүн амын тоо буурах хандлагатай байна.

Нийт мал сүргийн дотор тэмээ 0.2 хувь, адуу 5.2 хувь, үхэр 5.1 хувь, хонь 49.9 хувь, ямаа 39.6 хувийг тус тус эзэлж, хонин сүргийн хувийн жин хэвийн хэмжээнд байна. Цаашид бод малыг тогтвортой өсгөх бодлого боловсруулах шаардлагатай байна.

Аймагт “Сартуул” үүлдрийн хонь, “Завхан-буурал” үүлдрийн ямаа, Тэсийн голын хурдан удмын адууг үүлдэр омгоор батлуулж, цөм сүрэг болгон өсгөж байна.

Аймгийн дүнгээр 2015 оны байдлаар 12.2 мянган малтай өрх, 8.3 мянган малчин өрхийн 16.1 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна.

Газар тариалангийн үйлдвэрлэлээр жилийн хэрэгцээт төмс хүнсний ногооныхоо 41.2 гаруй хувийг орон нутагтаа үйлдвэрлэж, цаашид 70.0 хувьд хүргэх зорилт тавьж байна.

Амины малтай өрх нь аймгийн хэмжээний нийт өрхийн 58.8 хувийг эзэлж, малчдын 31.8 хувь нь 16-34 насны залуучууд, 56.1 хувь нь 35-55 насны хүн ам, 12.1 хувь нь тэтгэврийн насныхан эзэлж байна. Малчдын тоо өнгөрсөн оноос 2.0 хувиар өссөн ч, залуу малчдын тоонь 3.0 хувиар буурч, МАА-д 5,1 мянган малчин залуус ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нийт 1678 нэгж үйл ажиллагаа явуулж, аймгийн ерөнхий боловсролын 30 сургуульд 14.6 мянган хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролын 39 байгууллагад 6.1 мянган хүүхэд хүмүүжиж байна.

МУИС-ийн Завхан сургуульд маркетинг, санхүү банк, нягтлан бодох бүртгэл зэрэг 8 төрлийн мэргэжлээр 32 багш, 419 оюутан, СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежид 47 багш 203 оюутан сурагч, Политехник коллежид 17 мэргэжлээр 720

сурагч оюутан, 45 багштайгаар мэргэжлийн боловсролын үйл ажиллагаа явуулж байна.

Аймагт нэгдсэн эмнэлэг 2, сум дундын эмнэлэг 3, сумын эмнэлэг 19, өрхийн эмнэлэг 4, хувийн эмнэлэг 20, хувийн эмийн сан 23 ажиллаж, иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн хөгжлийн давуу болон сул талууд

Давуу тал:

- Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр
- Насны бүтцээр залуу
- Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөхөд ашиглаж болох мал аж ахуйн түүхий эдийн арвин нөөцтэй

- ОХУ-ын томоохон зах зээлд ойр дөт

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн үзэсгэлэнт газруудтай

Сул тал:

- Хүн амын тоо цөөн, өсөлт удаан
- Ажилгүйдэл ядуурлын түвшин өндөр
- Эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур байгаатай холбоотойгоор аймгийн татварын орлого бага, аймгийн төсөвт улсын татаас голлох үүрэгтэй учир эдийн засгийн хувьд хараат

- Зам харилцаа дэд бүтэц сул хөгжсөн

- Аймгийн дотоод зах зээлийн багтаамж бага, Монгол Улсын нийслэл болон төвийн бүсийн томоохон зах зээлээс алслагдсан

- 2016 оны байдлаар нийт нутгийн 14 хувь нь буюу 11 сум бэлчээрийн даац хэтэрсэн байна

- Нялхсын эндэгдэл, халдварт буюу халдварт бус өвчний гаралт ихсэх хандлагатай байдгаас шалтгаалан хүн амын дундаж наслалт бага

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор **“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталж нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхаргыг давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно**” гэсэн зорилтыг тусгасан.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга зам нь хүний мэдлэг, оюуны бүтээмж, экотехнологийн инноваци, гео-эдийн засгийн нэгдэл, сайн засаглал хэмээн үзэж байна.

Бидний хувьд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан аймгийн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, нийгмийн хуримтлагдсанасуудлуудыг шийдвэрлэх, ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орон нутгийг ирээдүйд өрсөлдөх чадвар бүхий бүс нутаг болгон хөгжүүлэх шаардлага тулгарч байгаа юм.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад эдгээр асуудлыг болон аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшин, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлага, эх орныхоо хөгжлийн тулгуур баримт бичгүүдийн үзэл санаа, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд, Намын мөрийн хөтөлбөрүүд, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, агентлагуудаас ирүүлсэн санал, тухайн салбарт олон жил ажилласан дадлага туршлагатай эрдэмтэн, судлаачид, салбарын мэргэжилтнүүд, хувийн

хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын дунд явуулсан санал асуулга, уулзалт хэлэлцүүлгээс гарсан санал, үр дүнг тусгасан болно.

Мөн тухайн зорилтыг хэрэгжүүлэх хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо судалгаа, өнөөгийн болон зорилтот хүрэх түвшин зэргийг шалгуур үзүүлэлт болгон нарийвчлан тооцож гаргав.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад ашигласан тулгуур баримт бичиг:

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн бодлого
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол
- Завхан аймгийн Хөгжлийн цогц бодлого 2009-2021
- Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан
- Завхан аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр-2016
- Завхан аймгийн Монгол ардын намын мөрийн хөтөлбөр-2016
- Монгол улсын болон аймгийн Статистикийн эмхэтгэл

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Ногоон хөгжил, иргэдийн идэвхитэй оролцоо, өндөр бүтээмж, оюуны чадавхид суурилсан, авлигаас ангид, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалтай, шударга ёс, тэгш эрх, хүний амьдрах ажиллах, хөгжих, таатай орчныг бүрдүүлсэн аймаг болох үндсийг тавина.

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Төр, засгийн бодлого үйл ажиллагаатай нийцсэн, орон нутгийнхаа онцлог, нөөц чадавхийг бүрэн дайчилсан, судалгаанд суурилсан эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

- Хүнд суртал, авлигаас ангид, ил тод нээлттэй байх
- Шударга ёс, тэгш байдлыг хангах
- Бодлогын залгамж чанарыг хадгалах
- Төрийн удирдлагын манлайлал, ил тод байдлыг ханган, ёс зүйг чанд мөрдөж, хариуцлагыг өндөржүүлэх
- Шинийг санаачилж, дотоод нөөц бололцоогоо бүрэн ашиглах
- Хүн бүрийн сэтгэл шингэсэн оролцоо, идэвхийг өрнүүлэх
- Шинэ технологи, инновацийг нэвтрүүлэх
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх
- Мэдээлэл, сургалт сурталчилгааг өргөжүүлэх
- Үйл ажиллагааны явцад хяналт үнэлгээ хийж, арга зүйгээр хангах

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Сайхан амьдралын баталгаа-Хөдөлмөр дагасан амжилт

Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй ил тод байдлыг дээшлүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нутгийн брэнд бүтээгдэхүүнээр үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, хүн амыг эрүүл чанартай хүнсээр хангаж, дэд бүтцийн хөгжлийг түргэтгэнэ.

1.1 САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ

Зорилт 1. Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шуурхай байдлыг хангуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Далд эдийн засгийг илрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
2. Аймаг, сумын эдийн засаг, нийгмийн бодит байдалд тулгуурлан төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой болгож эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.
3. Бүх шатанд төсвийн үр дүнтэй, хэмнэлттэй, хариуцлагатай байдлыг хангуулж хяналтын системийг сайжруулна.
4. Статистикийн тооллого, судалгаа, мэдээний чанарыг сайжруулж үр дүнг богино хугацаанд тархаан, удирдлагыг мэдээллээр хангана.

Хүрэх үр дүн Татварын орлого нэмэгдэж, эдийн засгийн таатай орчин бүрдэн төсвийн үр ашиг, тооллого, судалгаа, мэдээний чанар сайжирна.

Зорилт 2. Худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод нээлттэй болгож, төрийн болон орон нутгийн өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлэн хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт, бүртгэлийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Орон нутгийн өмч, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, хяналт тавих, ашиглаагүй илүүдэлтэй, дутагдалтай хөрөнгийн судалгааг гаргаж, өмчийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
2. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд аймгийн аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих бодлого баримтлан, онлайн хэлбэрийг өргөжүүлнэ.

Хүрэх үр дүн Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээг иргэд олон нийтэд ил тод, нээлттэй болж, өмчийн хадгалалт, хамгаалалт сайжирна.

1.2 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

Мал аж ахуй

Зорилт 1. Мал сүргийн зохистой харьцааг бүрдүүлж, бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй малыг өсгөх, малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалах, үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгон ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн мал сүргийг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
2. Сартуул үүлдрийн хонь, Завхан Буурал үүлдрийн ямааны удмын санг хамгаалах, ангилалт, сүрэглэн хээлтүүлэх, хээлтүүлэгч бойжуулах замаар малын ашиг шимийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Мал сүргийн чанар, үүлдэр угсаа сайжирч, нэг малаас авах ашиг шим нэмэгдэнэ.

Зорилт 2. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний чанарыг сайжруулж, мал сүргийг халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Мал эмнэлэг, үржлийн тасгийн чанарыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

2. Мал сүргийг халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд чанартай зохион байгуулж, өвчний гаралтыг аюулгүй түвшинд байлгана.

3. Мал сүргийг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд хамруулж, паразиттах өвчний гаралтыг бууруулна.

4. Байгаль орчин, цаг уур, экологийн өөрчлөлтөөс шалтгаалан гарч буй малын өвчлөлийн судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлнэ.

Хүрэх үр дүн Мал сүргийг эрүүлжүүлэн, хүн амыг эрүүл хүнсээр ханган зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлнэ.

Зорилт 3. Малчдын залуу халааг бэлтгэх, хөдөлмөрөө хорших, эрчимжсэн мал аж ахуй, фермийн үйл ажиллагааг дэмжинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Малчдын залуу халааг бэлтгэх “Залуу малчин өрх”, “Илгээлтийн эзэд” хөдөлгөөн өрнүүлж, залуу малчдад мал маллагааны тэргүүн туршлагыг нэвтрүүлэн малчдыг бэлтгэж, давтан сургана.

2. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх бага оврын техник нэвтрүүлэх, хөдөлмөрөө хорших санал санаачилгыг дэмжих, цөөн мал бүхий малчин өрхийг малжуулах, малчдын орон сууц барих, өвөлжөө хаваржааны хашаа хороо шинэчлэн засварлах хөдөлгөөн өрнүүлнэ.

3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дэмжин, хүн амыг эрүүл хүнсний бүтээгдэхүүнээр хангана.

4. Малчдын хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх “Сайн малчин” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний залгамж халааг бэлтгэж, дэвшилтэт технологи, тэргүүн туршлага нэвтэрнэ.

Зорилт 4. Мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлж, бэлчээр ашиглалтыг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Инженерийн хийцтэй худаг, уст цэг гаргах, шинээр хайгуул хийх, засварлах, гар худаг, хөв, цөөрөм байгуулах зэргээр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

2. Бэлчээрийн ашиглалтыг сайжруулах, нөхөн сэргээх, талхлагдал, цөлжилтийг бууруулах зорилгоор фотомониторингийн арга зүйг нэвтрүүлэн, бэлчээрт хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай байгаль орчинд халгүй дэвшилтэт аргаар тэмцэнэ.

Хүрэх үр дүн Бэлчээрийн усан хангамж нэмэгдэн, цөлжилт буурч ашиглалт сайжирна.

Зорилт 5. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, малчдын орлого, бүтээмжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулж, малын гаралтай түүхий эдийг уламжлалт аргаар стандартын дагуу боловсруулж, үнэ ханшийг тогтворжуулан үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

2. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн үйлдвэрлэлд инноваци, шинэ технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгон, малчид, иргэдийн орлого, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Мал аж ахуйн үйлдвэрлэлд инноваци нэвтэрч, бүтээмж дээшлэн, үйлдвэрлэл, ашиг орлого нэмэгдэнэ.

Газар тариалан

Зорилт 6. Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг ханган, аймгийн хүн амын хэрэгцээт гурилын 30 хувь, төмс хүнсний ногооны 70-аас доошгүй хувьд хүргэж, хүн амыг эрүүл, чанартай хүнсээр хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2. Хүн амын хэрэгцээт гурилын түүхий эдийн 30-аас доошгүй хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангана.

3. Төмс хүнсний ногоо, хүлэмж, тариалангийн талбай, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулж, аймгийн хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны хангамжийг 70-аас доошгүй хувьд хүргэнэ.

Хүрэх үр дүн Газар тариалангийн үйлдвэрлэл дээшилж, аймгийн хэрэгцээт гурил, төмс, хүнсний ногооны хангалтын хувь нэмэгдэнэ.

Зорилт 7. Газар тариалангийн үйлдвэрлэлд, техник тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи нэвтрүүлж, өвс тэжээл, үрийн нөөц бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улиастай суманд төмс, хүнсний ногооны механикжсан зоорь байгуулж, технологийн дагуу хадгалсан хүнсний ногоогоор хэрэглэгчдийг хангана.

2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн эрсдлээс хамгаалах, усалтын системийг шинээр барих буюу сэргээн засварлах замаар усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлнэ.

3. Хөдөө аж ахуйн техникийн дундын төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай техник тоног төхөөрөмж, дэвшилтэт технологи, стандарт шаардлага хангасан бордоо, ургамал хамгааллын бодисыг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоход дэмжлэг үзүүлнэ.

4. Аймагт төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн нутагшсан, ургац өндөртэй үрийн нөөц сан бүрдүүлнэ

5. Малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлж, аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүй нөөцийг өөрийн аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжээс бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн Хөрсний үржил шим сайжирч, өвс тэжээл, үрийн нөөц бүрдэн, хэрэглэгчдийг технологийн дагуу хадгалсан төмс, хүнсний ногоогоор ханган, тариаланчдын ажиллах таатай нөхцөл бүрдэнэ.

Зорилт 8. Зах зээлд эрэлт ихтэй, өрсөлдөх чадвартай эмийн болон хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. “Завханы улаан хальст саримс”-ыг дэлхийн брэнд болгох судалгааны ажлыг эхлүүлж, ногоочдын эрх ашгийг хамгаалан, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ.

2. Чацаргана дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, суль, сульхир зэрэг эмийн гаралтай ургамлын хэрэглээг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Зах зээлд өрсөлдөх чадвартай, эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ.

1.3 Аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ

Зорилт 1. Хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл баталгаат хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангана.

2. Улиастай, Тосонцэнгэл, Тэс сумдын махны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжин, экспортыг нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлэн үнийг тогтворжуулна.

3. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бүрдүүлнэ.

4. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэн, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын явцын хяналтыг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангана.

5. “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” аймгийн дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бэхжиж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ.

Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Сүү, цагаан идээ, жимс жимсгэнэ, тахиа, гахай, загасны аж ахуй эрхэлж буй иргэд, аж ахуй нэгжийг дэмжиж, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулна.

2. Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолыг орон нутагт үйлдвэрлэсэн илчлэг, амин дэмтэй шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэх иргэн, аж ахуй нэгжийн санаачилгыг дэмжинэ.

Хүрэх үр дүн Эрүүл хүнсний хангамж сайжирч, бүтээгдэхүүний нэр төрөл олширч, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэнэ.

Зорилт 3. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэн, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, улс, бүс, аймаг болон олон улсын чанартай үзэсгэлэн яармагийг жилд 2-с доошгүй удаа зохион байгуулна.

2. Төв, суурин газруудад бөөний худалдааны болон ахуй үйлчилгээний төв байгуулна.

3. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж, мэргэжлийн сургалт, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулна.

4. “Сайн бизнесмэн” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

5. Тэлмэн суманд баригдах дулааны цахилгаан станцыг түшиглэн бүс нутагт газар тариалан, аж үйлдвэр хөгжих эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн цар хүрээ нэмэгдэж, бизнесийн таатай орчин бүрднэ.

Зорилт 4. Орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн “Завхан бренд”-үүдийг бий болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Орон нутгийн бүтээгдэхүүнийг нэг дороос худалдах, борлуулах “Завхан бренд” нэрийн дэлгүүрийг Улаанбаатар хотод байгуулна.

2. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээг бий болгох “Стандартаар Завхан” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3. Жижиг дунд үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бүтээгдэхүүний мэдээллийн сан байгуулж, “Завханд үйлдвэрлэв” логог бий болгож үйлдвэрлэл эрхлэгчдэд эзэмшүүлнэ.

Хүрэх үр дүн Худалдаа үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, чанар, стандарт хэрэгжин, мэдээллийн сан бүрдэнэ.

Зорилт 5. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийн хүрээнд “Нэг сум-Нэг үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

2. Ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийг өргөжүүлж, эдийн засгийн хүрээг нэмэгдүүлнэ.

3. Хөнгөн үйлдвэрийн парк байгуулж, салбарын хамтын ажиллагааг дэмжин, кластерыг бүртгэлжүүлнэ.

4. Хөнгөлөлттэй зээл, тусламжийг шаардлага хангасан иргэн, аж ахуй нэгжид олгож, хяналтыг сайжруулан үр өгөөжийг дээшлүүлнэ.

Хүрэх үр дүн Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдэж, эдийн засгийн өсөлт бий болно.

Зорилт 6. Эко технологийг нэвтрүүлэн агаарын бохирдлыг бууруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Агаарын бохирдлоос сэргийлэх, гэр хорооллын хэрэглэгчдийг утаа багатай түлшээр хангах зорилгоор шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжинэ.

2. Малын гаралтай түүхий эдийг ашиглан Биогаз түлш үйлдвэрлэх ажлыг эхлүүлнэ.

Хүрэх үр дүн Төв суурин газрын агаарын бохирдол буурна.

Зорилт 7. Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд тавих хяналтыг сайжруулах, нөхөн сэргээх, газрын доройтлоос сэргийлэх, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Ашигт малтмал, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн барьцаа, албан татвар, хураамжийн мэдээллийг нээлттэй ил тод болгож, ашиглалтын үр дүнг нэмэгдүүлнэ.

2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээт бараа, ажил үйлчилгээ, ажиллах хүчнийг орон нутгаас хангах бодлого баримтална.

3. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлж уул уурхай, хайгуул олборлолтод өртөж эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээнэ.

Хүрэх үр дүн Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын хяналт сайжирч, байгаль экологийн тэнцвэрт байдал хангагдсан байна.

1.4 Дэд бүтэц

Зорилт 1. Улсын болон орон нутгийн чанартай авто зам, засвар, шинэчлэлтийг хийж, авто замын сүлжээг өргөжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улиастай-Алтай чиглэлийн 200 км замын ажлыг эхлүүлж, Дөрвөн зам-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км замыг хатуу хучилттай болгоно.

2. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Улиастай-Загастайн даваа чиглэлийн 67 км замыг хатуу хучилттай болгоно.

3. Төв, суурин газрын доторх замыг сайжруулж, хатуу хучилттай болгоно.

4. “Доной Нисэх буудал”-ын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн даланг хийж, гэрэл суултын систем суурилуулна.

Хүрэх үр дүн Зам, харилцаа сайжирч, иргэдийн ая тухтай аюулгүй зорчих болон эдийн засгийн таатай орчин бүрдсэн байна.

Зорилт 2. Аймаг, сумын орон нутгийн чанартай гүүр, давааг засварлан сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улиастай сумын Богд, Чигэстэй, Цагаанхайрхан сумын Ширээгийн голд төмөр бетонон гүүр барих ажлыг эхлүүлнэ.

2. Хүнгүй, Идэрийн гол болон сум, орон нутгийн чанартай гүүр шинээр барих техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

3. Отгон сумын Буянт баг, Алдархаан сумын Өвт болон Даян хайрхан, Эрдэнэхайрхан сумын Хар нуур чиглэл, Яруу сумаас Чигэстэй баг хүртэлх зам давааг засварлаж, сайжруулна.

4. Улаанхаалга амралт сувиллын газрын зам, гүүрийг засварлана.

Хүрэх үр дүн Орон нутгийн чанартай зам харилцаа сайжирна.

Зорилт 3. Хөдөөгийн багийн үүрэн холбооны чанар хүртээмжийг сайжруулах, мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээг өргөжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Яруу, Тэлмэн, Идэр сумдад Жи мобайлын үүрэн холбооны дахин дамжуулах станцыг өргөтгөх, Арц суурь боомт дахь хилийн Мэргэжлийн хяналтын хэлтсийг интернет сүлжээнд холбоно.

2. Аймаг, сумдыг Wi-Fi интернетийн сүлжээтэй болгон хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3. Улиастай сумын зарим баг болон Отгон суманд шилэн кабелин шугам татна.

Хүрэх үр дүн Мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээ өргөжиж, хэрэглээг нэмэгдүүлсэн байна.

Зорилт 4. Нийтийн тээвэр, хот тохижилтын үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдлыг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улиастай, Тосонцэнгэл сумдад “Автовокзал, оношилгооны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, Их-Уул сумын Идэрийн голын гүүрэн дээр төлбөр хураах цэгийг байгуулна.

2. Шуудан, нийтийн тээвэр үйлчилгээний нэгдсэн хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмж, шуурхай байдлыг дээшлүүлнэ.

3. Төв, суурин газрын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн зам талбай болон аймгийн төвийн “Төв гудамжинд цогц” тохижилт хийж, зам дагуух гэрэлтүүлгийг сайжруулан ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Гудамж талбайн өнгө үзэмж сайжирч, нийтийн тээврийн шуурхай, аюулгүй, ая тухтай байдал дээшилнэ.

Эрчим хүч

Зорилт 5. Эрчим хүч, дулааны хангамжийг өргөтгөн, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. 100мВт-ын цахилгааны, 35 мВт-н дулааны станцыг шинээр барих, Улиастай хотын төвлөрсөн дулааны шугам сүлжээний шинэчлэлтийн зураг төсвийг хийж, ажлыг эхлүүлнэ.

2. Улиастай хотын “Өлзийт багийн 21-р зуун жишиг орон сууцны хороолол”-ын дэд бүтцийн ажлыг эхлүүлнэ.

3. Улиастай хотод 3000м³ хүчин чадалтай бохир ус, цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, шугамын шинэчлэлт хийнэ.

4. Сумдын доторх 04 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын алдагдлыг бууруулж, цахилгааны дутагдалтай, шугам сүлжээгүй айл өрхийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангаж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаална.

5. Зарим сумдыг төвлөрсөн уурын зуух, халаалтын нэгдсэн шугам сүлжээнд холбоно.

6. Төвийн эрчим хүчний цахилгааны үнийн хөнгөлөлтөнд хамруулах асуудлыг судалж шийдвэрлэнэ.

7. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан аймгийн нөөц дулааныг хангах станцыг байгуулах ажлыг судална.

Хүрэх үр дүн Цахилгаан, дулааны хангамж нэмэгдсэн байна.

1.5 Хот төлөвлөлт, барилга, газар зохион байгуулалт

Зорилт 1. Аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтыг оновчтой төлөвлөж, ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эхлүүлнэ.

2. Газар олголтыг иргэдэд ил тод, нээлттэй болгож, газар шинээр эзэмшүүлэх, өмчлүүлэх явцыг хөнгөн шуурхай болгоно.

Хүрэх үр дүн Хот төлөвлөлт сайжирч, газар олголт ил тод шуурхай өгөөжтэй болно.

Зорилт 2. Барилгын материалын дотоодын борлуулалтыг нэмэгдүүлж, орон сууц барих иргэн, аж ахуй нэгжийг дэмжинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Барилгын материалын чанар хяналтын лабораторийн ажиллагааг тогтмолжуулж, барилга байгууламжийн чанарыг сайжруулна.

2. Улиастай суманд барилгын дулаалгын болон ханын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.

3. Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцны хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулна.

Хүрэх үр дүн Иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирч, барилга, байгууламжийн насжилт уртасна.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Ногоон хөгжил -Тогтвортой аялал жуулчлал

Байгаль орчныг хамгаалан тэнцвэрт байдлыг хангаж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ногоон орчинг бүрдүүлж, орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.1 Байгаль орчин, ногоон хөгжил

Зорилт 1. Орон нутгийн болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Тарвагатайн нурууны байгалийн цогцолборт газрыг 2309.8 га талбайгаар өргөтгөж, Хомын тал, Булнайн нурууг улсын тусгай хамгаалалтанд авна.

Хүрэх үр дүн Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдэнэ.

Зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. “Иргэн бүр мод таръя-Тарьсан модоо ургуулъя” аяныг өрнүүлж, өөрийн эзэмшлийн талбайгаа зүлэгжүүлэх, мод тарих аж ахуйн нэгж, иргэдийн санаачилгыг дэмжин, ногоон байгууламжийг 2 дахин нэмэгдүүлнэ.

2. Ойжуулалт, мод үржүүлгийн мэргэжлийн байгууллага, иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

3. Жилд 1000 га-аас доошгүй талбайд ойн хөнөөлт шавьж, хортонгийн судалгаа, тэмцлийн ажил хийж, ногоон хэрэм, ойн зурвасыг жилд 20 га-аар нэмэгдүүлж, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ.

Хүрэх үр дүн Байгаль орчны экосистемийн тэнцвэрт байдал сайжирч, ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэнэ.

Зорилт 3. Төв, суурин газрын хог хаягдал болон агаарын бохирдлыг бууруулах зохистой менежмент хэрэгжүүлж, хоггүй цэвэрч аймаг болно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. “Хавар, намрын их цэвэрлэгээ”-ний аяныг зохион байгуулж, хогийн төвлөрсөн цэгүүдийн хур хог хаягдлыг дарж улшлан зарим сумдын хогийн цэгийг салхины зөв чиглэлд шинээр байгуулна. ажлыг зохион байгуулна. /хасах/

Хүрэх үр дүн Орчны бохирдлыг багасгаж, иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ.

Зорилт 4. Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалалтад авч, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэн, ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Булаг шандны эхийг хамгаалах, тохижуулах, талхагдлаас сэргийлэх ажлыг үе шаттай хийнэ.

2. Төв суурин газрын ундны усны чанар, хүртээмжийг дээшлүүлж, нөөц эх үүсвэрийг хамгаалж, ариун цэвэр, ариутгалд тавих хяналтыг сайжруулна.

3. Хур, тунадас, гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм, усан сан байгуулна.

4. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гадаргын усны нөөц, горим болон цэвдэг мөстөлд үзүүлж байгаа нөлөөллийн судалгаа хийнэ.

Хүрэх үр дүн Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалан, гадаргын усны нөөц, ундны усны чанар сайжирна.

Зорилт 5. Ан амьтан, байгаль орчноо хайрлан хамгаалж, зүй зохистой ашиглана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Иргэд, олон нийтэд байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.

2. Аймгийн агнуур зохион байгуулалтыг хийж, агнуурын байршил болон бүс нутгуудад судалгааны чиглэлийг шинээр тогтооно.

Хүрэх үр дүн Байгаль экологийн тэнцвэрт байдал хангагдсан байна.

2.2 Аялал жуулчлал

Зорилт 1. Аялал жуулчлалыг аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгох, орон нутгийн онцлог, хэв маягт тулгуурлан жуулчдын сонирхлыг татахуйц бүтээгдэхүүн, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн аялал жуулчлалын бүс нутгуудад байгалийн үзэсгэлэнт газар, түүх дурсгалын үнэт үзмэрийн тохижилт хамгаалалтыг сайжруулан, жуулчдын тоог нэмэгдүүлж эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

2. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, жуулчны баазын хүчин чадлыг нэмэгдүүлэн, жишиг аялал жуулчлалын бааз байгуулна.

3. Улиастай суманд “Отгонтэнгэр” аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ.

4. Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн маршрутыг батлуулж, жуулчдын амрах отоглох, хоноглох газруудыг шинээр байгуулна.

5. Аймгийн аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн төв байгуулж, “Завхан аймгийн 9 гайхамшиг”-ийг тодруулан аялал жуулчлалын хөтөч товхимлыг гаргана.

6. Нүүдлийн соёл иргэншил, ахуй амьдралыг харуулсан аялал жуулчлалын эвент арга хэмжээг бүс нутгуудад зохион байгуулна.

7. Сум орон нутгийн соёл, байгалийн онцлог, нүүдэлчин ахуй, мал аж ахуйд түшиглэсэн иргэн, өрхийн оролцоог хангасан “Хот айл” аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн Завхан аймгийг зорин ирэх гадаад дотоодын жуулчдын тоо нэмэгдэж, аялал жуулчлалаас олох орлого өсч, орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдийн бизнесийн таатай нөхцөл бүрдсэн байна.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүнээ дээдэлсэн төрийн үйлчилгээ- Ээлтэй нийгэм

Иргэн бүрт ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг эрхэмлэн, сурч боловсрох таатай орчныг бүрдүүлэн, оюунлаг, эх оронч иргэнийг төлөвшүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн хамгааллыг зорилтот бүлгүүдэд чиглүүлж, гэрбүлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1 Эрүүл мэнд

Зорилт 1. Эрүүл мэндийн удирдлагын манлайллыг дээшлүүлэх, иргэн бүрт тэгш хүртээмжтэй, чанартай, ээлтэй тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн эрүүл мэндийн тогтолцоог 2016-2020 онд бэхжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Эмч, эмнэлгийн ажилтны манлайлал, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, үйлчлүүлэгчээ дээдэлсэн ээлтэй тусламж үйлчилгээ үзүүлнэ.

Зорилт 2. Хувийн эмнэлэг, эмийн сан, рашаан сувиллын үйл ажиллагааг дэмжиж, уламжлалт анагаах ухааныг орчин үеийн ололттой хослуулан эмчилгээ, сувилгааны чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Уламжлалт анагаах ухаан болон нөхөн сэргээх эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг өргөжүүлнэ.

2. Сумдын эмийн эргэлтийн сан, хувийн хэвшлийн эмийн сангуудад хяналт үнэлгээ хийж, хүн амын дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, аюулгүй эм зүйн тусламж үйлчилгээ нэвтрүүлнэ.

Зорилт 3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн оролцоог хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд тэгш, хүртээмжтэй үзүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг, хариу арга хэмжээг сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх хүүхдэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

3. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл зан үйлийг хэвшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

4. Элэгний хатуурал, хорт хавдраас сэргийлэх “Элэг бүтэн Монгол” дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

5. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, тандах болон төгс эмчлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.

6. ХДХВ/ДОХ, БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, зорилтот насны иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулан илрүүлэлтийг нэмэгдүүлж, хариу арга хэмжээ авна.

7. Умайн хүзүү, хөхний хорт хавдрын эрт илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

8. Зоонозын халдварт өвчин болох нохойгоор дамжин халдварладаг бэтэг өвчний халдварлалтын түвшин тогтоох суурь судалгаа хийж, хүн амыг халдвараас сэргийлэх арга хэмжээ авна.

Хүрэх үр дүн: Иргэдэд эрүүл зөв амьдралын хэв маяг төлөвшин, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд бүх нийтийн оролцоо нэмэгдэж, өвчний гаралт буурна.

Зорилт 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, дэвшилтэт технологи нэвтрүүлж иргэн бүрт ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Малчдын эрүүл мэндэд онцгой анхаарч, явуулын тусламж үйлчилгээг алслагдсан хүн амд жилд 1-ээс доошгүй удаа хүргэнэ.

2. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим сүлжээ, бүртгэл мэдээллийг сайжруулан, шинжилгээний хариуг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Улиастай сумын Нэгдсэн эмнэлгийн телемедициний сүлжээний чанар хүртээмжийг сайжруулж, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлгийг улсын клиникийн эмнэлгүүдтэй телемедициний сүлжээнд холбох, сум дундын статусаар ажиллуулах, иргэд орон нутагтаа оношлуулах, эмчлүүлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.

4. Яаралтай тусламжийг эрүүл мэндийн нэгж, цэг бүрт байгуулан, бэлэн байдлыг хангаж ажиллана.

5. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Иргэдэд эрүүл мэндийн тусламж, оношилгоо, үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэнэ.

Зорилт 5. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор ханган, нийгмийн баталгааг сайжруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад дотоодод мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцоход дэмжлэг үзүүлнэ.

2. “Сайн эмч” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Зорилт 6. Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, тоног төхөөрөмж, парк шинэчлэлтийг үе шаттай зохион байгуулна.

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт гемодиализийн эмчилгээний арга, хэвлийн хөндийн болон эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг нэвтрүүлж, микортон, тоног төхөөрөмжөөр хангана.

2. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудын шугам сүлжээ, засварын ажлыг хийж, шаардлагатай сумдын эрүүл мэндийн төвийг шинээр барих ажлыг эхлүүлнэ.

3. Аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудын парк шинэчлэлтийг үе шаттай хийнэ.

Хүрэх үр дүн Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагуудын ажиллах нөхцөл сайжирч, хүн амд үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна.

3.2 Нийтийн биеийн тамир, спорт

Зорилт 1. Нийтийн биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж, хүн амын амьдралын зөв хэв маяг, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Спортын мэргэжлийн холбоод, Өсвөрийн шигшээ багуудын үйл ажиллагааг дэмжиж, мэргэжлийн спортыг орон нутагт хөгжүүлнэ.

2. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Хаврын баяр” урлаг, спортын наадмыг жил бүр зохион байгуулна.

3. Нийтийн биеийн тамир, спорт, үндэсний спорт, иог, бясалгал, зохистой хөдөлгөөнийг хөгжүүлж, боловсон хүчнийг чадавхжуулан, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангаж, спорт заалны ашиглалтыг сайжруулна.

4. Нийтийн биеийн тамирын талбай, чийрэгжүүлэх танхим, ногоон байгууламж бүхий гүйлт алхалт, дугуйн зам байгуулан, сэргээн тохижуулан, бүх нийтийн эрүүл мэндийн аян өрнүүлнэ.

5. “Усан бассейн” бүхий спорт цогцолборыг ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангана.

Хүрэх үр дүн Нийтийн биеийн тамир, үндэсний спорт, зөв зохистой дасгал хөдөлгөөнөөр хичээллэгчдийн тоо нэмэгдэн, орчин сайжирч, тамирчдын амжилт ахисан байна

3.3 Боловсрол

Зорилт 1. Багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг нэмэгдүүлэн, хүүхдийн авъяас чадварыг хөгжүүлж, бүх шатны сургалтын амжилт чанарыг дээшлүүлэн хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймгийн боловсрол соёл, урлагийн салбарыг 2016-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Бүх шатны боловсролын байгууллагын хамран сургалтыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль, хүүхэд харах үйлчилгээ, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, сургалтын төв байгуулах санаачилгыг дэмжинэ.

3. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг дээшлүүлэх, ажлын үр дүнг дэмжих “Сайн багш” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4. Хариуцлагатай, бүтээлч, оюунлаг, нөхөрсөг, эх оронч үзэлтэй, эерэг хандлагатай иргэнийг төлөвшүүлэх “Оюунлаг Завханчууд” хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

5. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Оюуны наадам”-ыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлэн амжилттай оролцсон багш, сурагчдыг дэмжиж урамшуулна.

6. Завхан аймгийн Засаг даргын нэрэмжит “Оюутны тэтгэлэг”-ийг бий болгож, “Сайн оюутан” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн Багш, сурагчдын сурч, хөгжих авъяас, чадвар сайжирч, сургалтын чанар, хүртээмж дээшлэн, хүүхэд залуучууд эерэг зан суртахуун, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай иргэн болон төлөвшинэ.

Зорилт 2. Бүх нийтийн боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн сурч боловсрох, хөгжих таатай орчныг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. “Насан туршийн боловсролын төв болон нэгж”-үүд нь хүн амын насан туршийн боловсролыг дэмжигч, мэдээлэл түгээгч байх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, хөгжүүлэхэд иргэн, аж ахуй нэгж, эцэг эхийн санаачилгыг дэмжиж ажиллана.

Хүрэх үр дүн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, хамгааллын тогтолцоо сайжирч, бүх нийтийн сурч боловсрох таатай орчин бүрдэнэ.

Зорилт 3. Цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон дотуур байр, спорт заалыг шинээр барих, өргөтгөл хийх, засварлах ажлыг ээлж дараатай хэрэгжүүлж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Их-Уул сумын 640, Баянхайрхан сумын 160, Цэцэн-Уул сумын 160 хүүхдийн хичээлийн байрыг ашиглалтанд оруулна.

2. Шаардлагатай сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг шинээр барих, засварлах ажлыг ээлж дараатай хийнэ.

Зорилт 4. Их, дээд, ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийг оновчтой тогтоож, боловсрол, соёл урлагийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Ерөнхий боловсролын сургуулиудын бүтцийг оновчтой тогтооно.

2. Боловсрол, соёл урлагийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3. МУИС-ийн Завхан сургуулийн дэргэд “Бизнес инноваци” төвийг байгуулахад бодлогоор дэмжинэ.

4. СУИС-ийн харъяа Хөгжим бүжгийн коллежийг түшиглэн дуу хөгжмийн багш болон шаардлагатай мэргэжилтэн бэлтгэхэд хамтран ажиллана.

Хүрэх үр дүн: Хамтын ажиллагаа бэхжиж, шаардлагатай боловсон хүчнээр хангагдана.

3.4 Соёл, урлаг

Зорилт 1. Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, томоохон хэмжээний уран бүтээл туурвисан, амжилт гаргасан авъяаслаг уран бүтээлчийг дэмжинэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Завхан нутгийн бахархал, үндэсний өв соёл болон соён гэгээрүүлэхэд чиглэсэн томоохон хэмжээний уран бүтээл туурвихад дэмжинэ.

2. Аймгийн хөгжимт жүжгийн театр, сумдын соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, хөгжимт жүжгийн театрын дэргэд бага театр байгуулахыг дэмжинэ.

3. “Бадархундага” яруу найргийн наадмыг 2 жил тутамд зохион байгуулж, Б.Явуухулангийн нэрэмжит шагналыг бий болгон “Болор цом” наадамд амжилттай оролцсон нэг яруу найрагчид шагналыг олгоно.

4. Б.Явуухулангийн 90 жилийн ойд зориулан “Очирваанийн эгшиглэн” яруу найргийн наадмыг зохион байгуулна.

5. Яруугийн хүрээний туурийг сэргээж бурхан шашинтны төв байгуулах санаачилгыг дэмжинэ.

6. Хүн амын удмын сан “Угийн бичиг” хөтлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

7. Аймаг, сумын номын санд уншигчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн номоор баяжилт хийж, номын санчдын ур чадварыг дээшлүүлж, үйлчилгээг өргөжүүлнэ.

Хүрэх үр дүн Соёл, урлагийн байгууллагуудын цар хүрээ өргөжин, өөрийн аймгийн бахархал, үндэсний өв соёл хөгжинө.

Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагуудын ажиллах нөхцөлийг дээшлүүлэх, сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих, засварлах, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улиастай хотын Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлыг үргэлжлүүлнэ.

2. Тосонцэнгэл сумын соёлын төвийг “Сум дундын соёлын ордон” болгох, зарим сумдын Соёлын төвийг шинээр барих, засварлах ажлыг хийнэ.

Хүрэх үр дүн Соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмж дээшилж, орчин нөхцөл сайжирна.

Зорилт 3. Соёлын биет болон биет бус өв, түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалах, хамгаалах, сурталчлах ажлыг сайжруулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Аймаг, сумын орон нутаг судлах музейн үзмэрт баяжилт хийж, бүртгэлжүүлэх, камержуулах ажлыг эхлүүлнэ.

2. Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгал, хиргисүүр, булш бунхны хадгалалт хамгаалалт, тохижилтыг стандартын дагуу хийж, сурталчилна.

3. Шинээр олдсон түүхийн үнэт зүйлсийг соёлын өвд бүртгэж, биет бус соёлын өвийн судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

Хүрэх үр дүн Соёлын биет болон биет бус өв, үзмэрийн тоо нэмэгдсэн байна.

3.5 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил

Зорилт 1. Гэр бүлийн тулгуур үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг төлөвшүүлэх, хүүхэд, залуучуудын манлайлал-хөгжил, оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Гэр бүл, залуучуудын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх “Аз жаргалтай гэр бүл-Хүний хөгжлийн анхдагч орчин” хөдөлгөөнийг өрнүүлнэ.
2. “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
3. Хүүхэд залуучуудын ордныг түшиглэсэн “Хүүхэд хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг дэмжинэ.
4. Нийгмийн эмзэг бүлгийн болон хараа хяналтгүй хүүхдийн бүртгэл, хяналтыг сайжруулж, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг бууруулна.

Хүрэх үр дүн Зөв хандлага, зан үйлтэй гэр бүл бэхжиж, хүүхдийн эрх, хамгаалал сайжирч, залуучуудын нийгэмд эзлэх манлайлал-хөгжил, оролцоо дээшилсэн байна.

3.6 Нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал

Зорилт 1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, нийгмийн тусламж зайлшгүй шаардлагатай зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
2. Хүүхэд залууст ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх “Ахмадын сургаал алт” дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
3. Ахмад настны асаргаа сувилгаа, сэргээн засах үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
4. Ахмадуудад үзүүлэх нийгэм, соёлын үйлчилгээг өргөжүүлэн “Ахмадын ордон”-ы үйл ажиллагааг тогтворжуулна.
5. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдэд цахилгааны үнийн хөнгөлөлт үзүүлнэ.
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.
7. Зорилтот бүлгийн болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

Хүрэх үр дүн Иргэдийн эрүүл мэнд, нийгмийн даатгалаас авах үйлчилгээ хөнгөн шуурхай болж, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн тоо буурч, зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилнэ.

3.7 Хөдөлмөр эрхлэлт

Зорилт 1. Шинээр 4000-аас доошгүй ажлын байр бий болгож, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байргүй өрхийн 1-ээс доошгүй гишүүдийг байнгын ажлын байраар хангах “Нэг өрх-Нэг ажлын байр” зорилт дэвшүүлж ажиллана.
2. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах, дунд насны иргэдийг ажилд зуучлах, хөдөлмөр эрхлэлтээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулна.
3. Нийгмийн гурван талт түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлж, “Зөвлөлдөх ардчилал”-ыг хөгжүүлнэ.
4. Зах зээлийн эрэлтэд нийцсэн ажилтан бэлтгэх, төгсөгчид болон мэргэжлийн боловсрол эзэмшигчдийг өөрийн ажлын байрыг бий болгоход чиглэсэн үйл

ажиллагааг дэмжиж, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулна.

5. Шинээр ажлын байр олноор бий болгох, өөрөө өөртөө ажлын байр бий болгосон иргэдийг дэмжих, тогтвортой үйл ажиллагаа явуулж аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй аж ахуйн нэгжийг урамшуулна.

6. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлж, шинээр ажлын байрыг бий болгоно.

Хүрэх үр дүн Ажилгүйдлийн түвшин буурч, байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо нэмэгдэж, иргэд ажил, мэргэжлийн чиг баримжаатай болно.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Иргэний оролцоо-Сайн засаглал

Хууль иргэн бүрт эрх тэгш, шударга үйлчилдэг, хүний эрхийг дээдэлсэн иргэн бүрийн идэвхи, сэтгэл шингэсэн оролцоог хангасан, манлайллыг эрхэмлэсэн сайн засаглалыг бэхжүүлнэ.

4.1 Төрийн алба

Зорилт 1.Төрийн үйлчилгээнд цахим, дэвшилтэт технологи нэвтрүүлж, иргэдэд үзүүлэх төрийн байгууллагын шуурхай байдлыг дээшлүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. "Төрийн цогц үйлчилгээг багт" арга хэмжээг хөдөөгийн багийн иргэдэд зохион байгуулж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.Төрийн үйлчилгээг шуурхай болоход чиглэсэн дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлж, бүрдүүлэх бичиг баримтын нэр төрлийг цөөлж, хялбаршуулна.

3. Аймаг, сумдын "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, ажиллах нөхцөлийг сайжруулна.

4. Хууль, эрх зүй, нийгэм, эдийн засгийн мэдээллийг тусгасан "Таны туслагч" гарын авлага, товхимлыггаргаж бүх өрхөд хүргэнэ.

5. Аймгийн хөгжилд иргэн бүрийн сэтгэл шингэсэн, идэвхитэй, бүтээлч оролцоог нэмэгдүүлэх аяныг өрнүүлж, хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн Иргэдийн оролцоо нэмэгдэж, төр, засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилт, цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай авах боломж бүрдэнэ.

Зорилт 2. Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвар, манлайллыг дээшлүүлэх, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэн, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний стандартыг мөрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Төрийн жинхэнэ албанд анх орох болон удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр ил тод, нээлттэй зохион байгуулна.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын оновчтой тогтолцоог орон нутагт бий болгож, үр дүнг дээшлүүлнэ.

3. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадварлаг байх нөхцөлийг дэмжин, гадаад дотоодын сургалтанд хамруулж, туршлага солилцоно.

4. Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээнд дагаж мөрдөх стандартыг боловсруулж мөрдүүлнэ.

5. Нутгийн захиргааны байгууллагуудын конторын барилгыг шинээр барих, засварлах, багийн Засаг дарга нарыг унаажуулах, автомашины парк шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ.

6. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлж, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн албаны нэр хүндийг өсгөнө.

Хүрэх үр дүн Төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ шуурхай болж, төрийн албан хаагчийн хариуцлага өндөржин, ур чадвар дээшилнэ.

Зорилт 3. Төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлэх үйлчилгээнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг өргөжүүлэн, жендерийн эрх тэгш байдлыг хангуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Улаанбаатар хотод Завхан аймгийн орон нутгийн төлөөлөгчийн газар байгуулна.

2. Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгэм, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор чанартай гүйцэтгүүлэн, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

3. Төрийн байгууллагуудаас хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах харилцааг нэмэгдүүлнэ.

4. Жендерийн тэгш байдлыг хангаж, орон нутгийн хөгжлийн онцлог, нийгмийн хэрэгцээнд суурилсан оролцоог тэгш хангасан жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа өргөжиж, мэдээллийн ил тод, байдал дээшилсэн байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Зорилт 4. Гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэн өргөжүүлж, санхүү эдийн засгийн таатай орчныг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Монгол төрийн гадаад нэгдмэл байдлыг хадгалж, хөрш болон бусад орнуудтай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэн, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг гүнзгийрүүлнэ.

2. Орон нутаг дахь гадаадын иргэн, харъяатын бүртгэл хяналтыг сайжруулна.

Хүрэх үр дүн Гадаад хамтын ажиллагаа өргөжин, нийгэм, эдийн засгийн боломж сайжирна.

4.2 Хууль, эрхзүй

Зорилт 1. Хүний эрхийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлд төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангаж, эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хүний эрхийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх "Эрх зүйн боловсрол-Эрс өөрчлөлт" дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2. Албан тушаалтны ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, хариуцлага тооцох, тайлагнах ажлыг хэвшүүлэх "Нийтийн албаны ёс зүйн дүрэм"-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

3. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

4. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, хэрэглэгчийн эрхийн болон өрсөлдөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулна.

5. "Авлигын эсрэг-Авлигаас ангид аймаг" дэд хөтөлбөрийг боловсруулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

6. "Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийн хүрээнд улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангуулж, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Эрх зүйн сургалт сурталчилгааны хүртээмж нэмэгдэж, иргэдийн эрх зүйн боловсрол дээшилнэ.

Зорилт 2. Гэмт хэрэг, зөрчлөөс иргэдийн оролцоотой урьдчилан сэргийлэх замаар аюулгүй, амар тайван байдлыг хангаж ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Терроризм, цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, техник хангамжийг сайжруулна.

2. Иргэдийн оролцоонд түшиглэж “Олон нийтийн цагдаа”-г ажиллуулах бодлого баримтална.

3. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэх, урьдчилан сэргийлэх болон хүчирхийллээс ангид байх орчин нөхцөлийг бүх шатанд бүрдүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

4. Согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хор уршгийг таниулах “Архигүй-хамт олон” хөдөлгөөн өрнүүлнэ.

5. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, малын хулгайг илрүүлэхэд онцгой анхаарна.

6. Аймгийн төв болон томоохон суурин газрын гудамж талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна.

Зорилт 3. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын ажлын уялдааг хангаж, хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хил хамгаалалтын холбооны техник хангамжийг сайжруулж, Арц суурийн хилийн боомтыг өргөжүүлнэ.

2. Шүүхийн шинжилгээний албаны чанар, шуурхай байдлыг дээшлүүлж, техник хангамжийг сайжруулна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны байрыг ашиглалтад оруулж, Цагдан хорих байрны нөхцөлийг сайжруулан, ял эдлүүлэх ажиллагаанд цахим, теле хяналтын камерыг нэвтрүүлж, шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн шуурхай байдлыг дээшлүүлж, дэмжлэг үзүүлнэ.

4. Төрийн архивыг стандарт шаардлагад нийцүүлж орон нутгийн нөөц боломжид түшиглэн хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

5. Архивын баримт бичгийн 60 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн сангбаяжуулна.

6. Аймгийн Шүүх, Прокурор болон Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжих бодлого баримтална.

Хүрэх үр дүн Төрийн болон тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа бэхжинэ.

4.3 Батлан хамгаалах

Зорилт 1. Цэргийн алба хаах насны иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, иргэдэд эх орноо хамгаалах, цэргийн боловсрол, бэлтгэл эзэмшүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Зэвсэгт хүчин болон бусад цэргийг зайлшгүй хүн, хүч бүрэлдэхүүнээр хангах тухай Засгийн газрын захиалгат даалгаврыг биелүүлнэ.

2. Аймгийн дайчилгааны төлөвлөгөөнд тогтоосон хугацаанд тодотгол хийж, даалгаваржуулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3. Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт явуулах “Сургалтын төв”-ийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

4. Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орноо хамгаалахад оролцох, цэргийн боловсрол, бэлтгэл эзэмшүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн Цэргийн боловсрол олгох сургалтын чанар сайжирч, цэргийн насны залуучуудын эх оронч хүмүүжил төлөвшинө.

4.4 Онцгой байдал

Зорилт 1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд мэргэжлийн анги, иргэдийг сургаж дадлагажуулан, бэлэн байдлыг хангуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын дадлага сургуулилтыг сум, орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.

2. Аж ахуйн нэгж байгууллага, айл өрхөд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалт хийж, заавар зөвлөмжөөр хангах, объектын гал түймэр унтраах сайн дурын хэсэг байгуулна.

Зорилт 2. Гамшгийн эрсдлийг тооцоолж, эмзэг байдлын эрсдлийн үнэлгээ хийж, болзошгүй цагийн байдлын үед аймаг, сумдын нөөцийн санд хэрэглэх эх үүсвэрийг төлөвлөнө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор аймгийн хэмжээнд тохиолдож болзошгүй гамшгийн төрөл бүрээр эрсдлийн үнэлгээ хийнэ.

2. Байгаль цаг уурын болон бусад хүндрэл нөхцөл үүссэн тохиолдолд зарцуулах эрсдлээс хамгаалах санг сум бүрт байгуулах хөдөлгөөнийг өрнүүлнэ.

Зорилт 3. Аймгийн гамшгаас хамгаалах аюулт үзэгдэл, ослын мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, албадын гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Орон нутагт тохиолдож байгаа аюулт үзэгдэл, ослын тухайгамшгийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэнэ.

2. Тосонцэнгэл сумын Онцгой байдлын хэлтсийг Аврах салбар байгуулах, Тэс сумын Онцгой байдлын албыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүнийг сургах, дадлагажуулах талбайг тохижуулж, шаардлагатай техник хэрэгслийн дэмжлэг үзүүлнэ.

Хүрэх үр дүн Гамшгаас хамгаалах аюулт үзэгдэл, ослын мэдээллийн сан бүрдэж, алба ангиудын хүрээ өргөжиж, чадавх дээшилнэ.

Үйл ажиллагааны хөтөлбөрийн товъёог

д/д	Бодлогын нэр	Салбарын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо
1	Эдийн засгийн хөгжил	Санхүү, эдийн засаг	6
		Хүнс, хөдөө аж ахуй	24
		Аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ	24
		Дэд бүтэц	21
		Хот төлөвлөлт, барилга, газар зохион байгуулалт	5
1-р бодлогын арга хэмжээний тоо			80
2	Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжил	Байгаль орчин	12
		Аялал жуулчлал	7
2-р бодлогын арга хэмжээний тоо			19
3	Нийгмийн хөгжил	Эрүүл мэнд	22
		Нийтийн биеийн тамир, спорт	5
		Боловсрол	14
		Соёл урлаг	12
		Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил	4
		Хөдөлмөр, нийгмийн халамж нийгмийн даатгал,	6
		Хөдөлмөр эрхлэлт	6
3-р бодлогын арга хэмжээний тоо			69
4	Засаглал	Төрийн алба	15
		Гадаад харилцаа	2
		Хууль, эрх зүй	18
		Батлан хамгаалах	4
		Онцгой байдал	7
4-р бодлогын арга хэмжээний тоо			46
Нийт арга хэмжээний тоо			214

ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙГДЭХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь уг хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эрсдлийн удирдлагаар хангахад оршино.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын зорилтын хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

Нэгдүгээр үе шат 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор эхний шатны үнэлгээ хийх

Хоёрдугаар үе шат 2020 оны эхний хагаст эцсийн шатны үнэлгээ хийх

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэн дүгнүүлнэ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэс нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, тогтоосон хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, үнэлгээний тайлангийн талаар оролцогч талууд, хэрэглэгчдэд мэдээлж, сурталчлах үүрэг хүлээнэ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт тус бүрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлж үнэлэлт дүгнэлт гаргуулснаар хэрэгжилт, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хуралдаанд танилцуулна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.

2016 ОНД ХУГАЦАА ДУУСЧ БАЙГАА АЙМГИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

- 1.Хүнсний баталгаат байдал хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2010 оны 19 дүгээр тогтоол /2009-2012,2012-2016 /
- 2.Чацаргана хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2010 оны 62 дугаар тогтоол /2010-2012, 2013-2016/
- 3.“Завхан хүүхэд” хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 111 дүгээр тогтоол /2012-2016/
- 4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 88 дугаар тогтоол /2013-2016/
- 5.Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 54 дүгээр тогтоол /2012-2016/
- 6.Эрүүл хот, дүүрэг, сум баг, ажлын байр, сургууль дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 53 дугаар тогтоол /2012-2016/

ХЭРЭГЖИХ ХУГАЦАА ДУУССАН БОЛОВЧ ШИНЭЧЛЭН БАТАЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

- 1.Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 11 дүгээр тогтоол /2012-2016/
- 2.Боловсролын салбарыг 2009-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
Аймгийн ИТХ-ын 2009 оны 30 дугаар тогтоол /2009-2015/
- 3.Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 54 дүгээр тогтоол /2012-2016/
- 4.Эрүүл хот, дүүрэг, сум баг, ажлын байр, сургууль дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 53 дугаар тогтоол /2012-2016/

ОДОО ХЭРЭГЖИЖ БАЙГАА БОЛОН ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХЭРЭГЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

- 1.Ус дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2011 оны 40 дүгээр тогтоол /2011-2021/
- 2.Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2012 оны 09 дүгээр тогтоол /2012-2020/
- 3.Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2016 оны 06 дүгээр тогтоол /2016-2020/
4. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2013 оны 11 дүгээр тогтоол /2012-2016/
- 5.Мод, модон эдлэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр

Аймгийн ИТХ-ын 2013 оны 100 дугаар тогтоол /2013-2016,2016-2020/

- 6.Завханд үйлдвэрлэж, Завханчууд хэрэглэж экспортлох хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2015 оны 18 дугаар тогтоол/ 2015-2016,2017-2020/
- 7.“Завханы улаан хальст саримс” дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2014 оны 3/01 дугаар тогтоол /2014-2015, 2016-2020/
- 8.Жендерийн тэгш хангах дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2015 оны 74 дүгээр тогтоол /2016-2020/
- 9.Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2014 оны 87 дугаар тогтоол /2015-2020/
- 10.Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2015 оны 44 дүгээр тогтоол /2014-2021/
- 11.Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр
Аймгийн ИТХ-ын 2016 оны 05 дугаар тогтоол /2016-2020/
- 12.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр
/Аймгийн ИТХ-ын 2013 оны 125 дугаар тогтоол 2014-2018/
- 13.Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр

2016-2020 ОНД БАТЛАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИНЭ ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

- 1.“Аймгийн мал сүргийг эрүүлжүүлэх, чанар ашиг шимийг сайжруулах хөтөлбөр”
- 2.“Сайн малчин” хөтөлбөр
- 3.“Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” дэд хөтөлбөр
- 4.“Стандарттай Завхан” хөтөлбөр
- 5.“Сайн бизнесмэн” хөтөлбөр
- 6.“Хог хаягдлын менежментийг сайжруулах” дэд хөтөлбөр
- 7.“Элэг бүтэн Монгол” дэд хөтөлбөр
- 8.“Сайн эмч” хөтөлбөр
- 9.“Сайн багш” хөтөлбөр
- 10.“Боловсрол соёлын салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр
- 11.“Оюунлаг Завханчууд” хөгжлийн хөтөлбөр
- 12.“Сайн оюутан” хөтөлбөр
- 13.“Ахмадын сургаал алт” хөтөлбөр
- 14.“Авлигын эсрэг-Авлигаас ангид аймаг” дэд хөтөлбөр
- 15.“Эрх зүйн боловсрол-Эрс өөрчлөлт” дэд хөтөлбөр

ГАРЧИГ